

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 37 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны арван хоёрдугаар сарын 25-ны 14 цаг 03 минутад эхэлж, 15 цаг 30 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 27 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Лхагважавын Отгонбаатарыг Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх 2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт нэр заасан иргэн Лхагважавын Отгонбаатарыг Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ч.Мөнхбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Үндсэн Хуулийн Цэцийн Тамгын газрын зарим ажилтныг удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн

<p>дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> - Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн дарга - Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга 	<p>жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.Нарангэрэлийн Болортунгалагийг Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэгт санал болгох.</p> <p>2.Энэхүү тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.Галбаабадраагийн Даваалайг Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэгт санал болгох.</p> <p>2.Энэхүү тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	---

3	<p>Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 65 төрийн албан хаагчдыг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах:</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p> <ul style="list-style-type: none"> - Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалтын захиргааны сул орон тоог нөхөх - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын сул орон тоог нөхөх - Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын сул орон тоог нөхөх 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын</p>

		<p>захиргааны төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 4 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан 1 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, өрсөлдсөн албан тушаалд томилохыг Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргадад үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 12 дугаар сарын 05, 06, 07-ны өдрүүдэд Нийслэлд зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн</p>
--	--	--

		<p>жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Нийслэлд 2014 оны 12 дугаар сарын 05, 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 218 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл /Ё.Гэрэлчулуун/-д үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ</p>
--	--	--

		<p>албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 12 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25 - ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Дундговь аймагт 2014 оны 12 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 10 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 7 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 7 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 14 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг</p>
--	--	--

		<p>баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлд үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтаар иргэд бүртгүүлэхгүй байгаа төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны талаар танилцуулах</p>	<p>Мэргэшлийн шалгалтын Төв комиссын нарийн бичгийн даргын орон нутагт иргэд бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны талаар хийсэн судалгаа, сонсголыг хэлэлцээд эдгээр ажлын байрны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим сайтад байнгын булан нээж ажиллуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;</p> <p>Хүн бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны судалгааг Хөдөлмөрийн яаманд хүргүүлж Хөдөлмөрийн төв бирж болон хувийн биржүүдийн мэдээллийн санд оруулах, цахим хаягтай холбох;</p> <p>Орон нутагт иргэд бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны талаарх судалгаа нөхцөл шалтгааны талаарх саналаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргэх зэрэг саналыг дэмжив.</p>
6	<p>Бусад асуудал /2008-2012 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайдаар ажиллаж байсан Д.Нямхүүг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай/</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайдаар 2008-2012 онд томилогдон ажиллаж байсан Даваагийн Нямхүүг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ